

## ӨМНӨХ ҮГ

МУИС-ийн Геологийн салбараас эрхлэн гаргадаг МУИС-ийн Эрдэм шинжилгээний бичиг цувралын Геологийн асуудлууд сэтгүүлийн ээлжит дугаар №19 (554) та бүхэнд хүрч байна. Энэ удаагийн дугаарт зонхилон тунамал савд хуримтлагдсан хурдас, ашигт малтмалын судалгааны өгүүллүүд орсон болно. Энэ нь зарим гадны сэтгүүлүүд сэдэвчилсэн судалгааны чиглэлээр тусгай дугаар гаргадаг жишгийг дотооддоо нэвтрүүлэх цаашдын зорилготой холбоотой. Хэдий тийм боловч сэтгүүл хэвлэгдэх хугацаанд ирүүлсэн бусад чиглэлийн цөөн өгүүллийг мөн оруулав.

Геологийн асуудлууд сэтгүүлийг энэ оноос эхлэн жилд 2 дугаар хэвлэхээр болсны зэрэгцээ, хэвлэх өгүүлэлд тавих шаардлагыг шинэчилж, мэргэжлийн хяналтыг сайжруулж байгааг Редакцийн зөвлөлөөс тэмдэглэж байна. Мөн энэ дугаараас өгүүллэгийн Харилцах зохиогчийн мэдээллийг оруулж эхлэв.

Сэтгүүлийн хаврын дугаарыг 5 сард, өвлийн дугаарыг 11 сард хэвлэх бөгөөд редакцийн зөвлөл зохиогч нараас өгүүллэг [oyunjargal@num.edu.mn](mailto:oyunjargal@num.edu.mn) (Л.Оюунжаргал) хаягаар жилийн турш, тогтмол хүлээн авна. Сэтгүүл хэвлэгдэх хүртэл хяналт хийгдэж, хэвлэгдэхээр зөвшөөрөгдсөн өгүүллэгийг өөрийн вэб хуудсын “Хэвлэгдэхээр хүлээгдэж буй өгүүллэг” хэсэгт байршуулж, нийтийн хүртээл болгоно. Геологийн асуудлууд сэтгүүлд судалгааны өгүүллэгээс гадна шинээр хийгдэж буй геологийн судалгаа, эрэл хайгуулын ажлын үр дүнгийн мэдээлэл, шинэ номын шүүмж зэргийг хүлээн авч, хэвлэнэ.

Эрхэм уншигч, геологичид Та бүхэн Геологийн асуудлууд сэтгүүлийн сүүлийн дугааруудад хэвлэгдсэн өгүүллэгийг дараахи хаягаар уншаарай ([http://gimar.num.edu.mn/?page\\_id=888](http://gimar.num.edu.mn/?page_id=888)).

Сэтгүүлийн энэ удаагийн дугаар, зохиогчдын өгүүлэлтэй холбоотой санал, зөвлөмж, шүүмж байвал сэтгүүлийн редакцид (Б.Эрдэнэцогт, [tsogo@num.edu.mn](mailto:tsogo@num.edu.mn); Х.Уламбадрах, [ulambadrakh@num.edu.mn](mailto:ulambadrakh@num.edu.mn); Д.Оюунжаргал, [oyunjargal@num.edu.mn](mailto:oyunjargal@num.edu.mn)) эсвэл МУИС, ШУС-ийн Геологи, геофизикийн тэнхимд хаяглан ирүүлэхийг хүсье.

## РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ  
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ  
ГЕОЛОГИ ГЕОФИЗИКИЙН ТЭНХИМ

## ГЕОЛОГИЙН АСУУДЛУУД Дугаар 19 (554)

2000 оноос хэвлэв.  
ISSN:2313-8408

Дугаарыг эрхэлсэн:  
Бат-Оршихын ЭРДЭНЭЦОГТ (ерөнхий редактор)  
Хөхөөдэйн УЛАМБАДРАХ  
Лувсаннъямын ОЮУНЖАРГАЛ

Хавтасны зураг: Завхан аймаг Отгон сум Отгонтэнгэр хайрхан, Б.Тамир

МУИС хэвлэх үйлдвэрт хэвлэв